

# НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

## ИЛТГЭХ ХУУДАС

2023 оны 12 дугаар сарын 18

Улаанбаатар хот

Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

“Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө”-д туссан байгууллагын хяналтад авсан 7 арга хэмжээ, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан 2 арга хэмжээний хэрэгжилтэд 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдөр үр дүнд суурилсан эцсийн дүн шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор (ЗГ-ын 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон) батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2, 6.2.3, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх журам”-д тус тус үндэслэн үнэлсэн болно.

6.2.1.Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ;

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

6.2.2.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно;

6.2.2.1.Зорилт арга хэмжээний хүрэх түвшинд хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан , гол үр дүн гарч эхэлж байгаа бол 90.0%

6.2.2.2.тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь

6.2.2.3.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь

6.2.2.4.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30.0 хувь

6.2.2.5.тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгааг хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол

0 хувь

6.2.3.Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалаар тооцож, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно.

6.2.3.1. **“Үр дүнтэй”**-зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100%;

6.2.3.2. **“Тодорхой үр дүнд хүрсэн”**-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь;

6.2.3.3. **“эрчимжүүлэх шаардлагатай”**-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтот чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 30-70 хүртэл хувь;

6.2.3.4. **“үр дүнгүй”**-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

Тайлангийн хэрэгжилтийг тооцохдоо тайлант хугацааг 2023.01.01- 2023.12.31-ний хүртэлх хугацааг 100 хувиар тооцож, 0-100 хувиар үнэлсэн болно.

Бодлогын баримт бичигт туссан 7 арга хэмжээний /Захиргаа, төлөвлөлт санхүүгийн хэлтэс- 6 арга хэмжээ, Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба-1/ хэрэгжилтийг Хүний нөөц, сургалт хариуцсан ажилтан А.Номинзул холбогдох журмын 36 хавсралтын дагуу нэгтгэсэн байна.

## 1.Хэрэгжилт

Байгууллагын хяналтад авсан “Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөө”-ний нийт 7 арга хэмжээг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс 6 /100%/, Инженерийн байгууламжийн ашиглалт, үйлчилгээний алба 1 /100%/, арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэвэл:

№	“Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ	Хэрэгжилт 2023 оны эхний хагас жил	Хэрэгжилт 2023 оны жилийн эцэс	Тайлангийн үнэлгээ
1	2	3	4	5
1	3.1.4.5.“Төрийн худалдан авах ажиллагаагаар	Нийтлэг үйлчилгээний газрын худалдан авах ажиллагааны ажлын хэсэг нь “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр	2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Төндэрт шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан нийт 62 нэр	100%

	дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дүгээр зүйл. Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах заалтын дагуу худалдан авалтыг зохион байгуулан ажиллаж байна. Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 70 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс худалдан авч, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, байгууллагын худалдан авалтыг “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дүгээр зүйл. Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах заалтын дагуу 70 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн байхаар зохион байгуулан, төрийн албан хаагчдад эрүүл, чанартай бүтээгдэхүүнээр хоол, зоогийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	
2	4.1.1.2. “Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.	Хурлын танхимын захиалгыг цахимаар хүлээн авдаг болсноор энэ оны эхний хагас жилийн байдлаар байдлаар нийт 286 удаагийн үйл ажиллагаа хүлээн авч, давхардсан тоогоор 5720 хүнд цай кофе болон хурлын үйлчилгээг үзүүлсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хурлын танхимын захиалга 2,6 дахин бувуу 164%-иар өссөн эерэг үзүүлэлтийг харуулж байна.	Хурлын танхимын захиалгыг цахимаар хүлээн авдаг болсноор 2023 оны жилийн эцсийн байдлаар НЗДТГ-ын 542 хурал, НИТХ-ын 18 хурал нийт 560 удаагийн хурлын танхимын захиалга хүлээн авч, давхардсан тоогоор 18600 хүнд цай кофе болон хурлын үйлчилгээг үзүүлсэн байна.	100%
3	4.1.1.3. “Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулах.	Нутгийн захиргааны байгууллагуудын <a href="http://www.erp.ulaanbaatar.mn">www.erp.ulaanbaatar.mn</a> дотоод удирдлагын систем “Дижитал Монгол” хөтөлбөрийн хүрээнд E-DOC системийн баримт боловсруулалт модулийг ашиглан албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд нийт 158 албан бичгийг 100 хувь тоон гарын үсгээр баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан байна.	Нутгийн захиргааны байгууллагуудын <a href="http://www.erp.ulaanbaatar.mn">www.erp.ulaanbaatar.mn</a> дотоод удирдлагын систем “Дижитал Монгол” хөтөлбөрийн хүрээнд E-DOC системийн баримт боловсруулалт 12 албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулан тайлант хугацаанд нийт 326 албан бичгийг 100 хувь тоон гарын үсгээр баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан байна.	100%
4	4.1.2.2. “Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас “Ээлтэй орчин бүрдүүлэх нь” сэдэвт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас “Ээлтэй орчин	100%

	<p>бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.</p>	<p>сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр нийт 21 байр хариуцсан менежерүүд, угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Б.Амаржаргал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ш тэргэнцрийг гардуулж өгсөн.</p>	<p>бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Байр хариуцсан менежерүүд, Угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Б.Амаржаргал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ш тэргэнцрийг хүлээлгэн өгсөн. Тус тэргэнцрүүдийг НЗЗ-ны байруудад иргэдэд хүртээмжтэйгээр байршуулан үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.</p>	
5	<p>4.1.4.1.“Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.</p>	<p>Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажиллалаа. Шилэн дансны веб хуудаст 23 төрлийн тайлан, мэдээг 46 удаа тухай бүр нь хугацааны хоцрогдолгүй байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.</p>	<p>Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажиллалаа. Шилэн дансны веб хуудаст 23 төрлийн тайлан, мэдээг 105 удаа тухай бүр нь хугацааны хоцрогдолгүй, 8 мэдээллийг хугацаа хоцорч байршуулан төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажилласан.</p>	100%
6	<p>4.2.2.1.“Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог бууруулах</p>	<p>Байгууллагын 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, 9 албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны дотор <a href="https://meduuleg.iaac.mn/">https://meduuleg.iaac.mn/</a> сайтад байршуулан ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дугаар тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан 2023 оны 05 сарын 01-ний өдрөөс 06</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тараах материал, гарын авлагыг Нийслэлийн Засаг захиргааны I, II, III, IV, Va, Vбв, Төр захиргааны цогцолбор байр, Нийслэлийн үйлчилгээний Нэгдсэн төв Мишээл, Драгон, Дүнжингарав салбар, Сэлбэ Баянхошуу дэд төвүүдийн нийт 12 байрны мэдээллийн самбарт, Байгууллагын</p>	90%

		<p>сарын 01-ний өдөр хүртэл 1 сарын хугацаатай “Би өгөхгүй, авахгүй” нөлөөллийн аяныг Нийслэлийн Засаг захиргааны 12 байршилд зохион байгууллаа. Аяны хүрээнд байгууллагын нийт 274 албан хаагчдад авлигын хор уршиг, сөрөг нөлөөлөл мөн урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангасан. Мөн тухайн байруудад үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн алба хаагчид, үйлчилгээ авч буй иргэдэд Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах зорилготойгоор авлигын эсрэг гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг тараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.</p>	<p>www.khangardi.mn сайт, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын фэйсбүүк хуудсанд АТГ-аас гаргасан шторк бичлэгийг тогтмол байршуулан ажиллалаа. Тайлант хугацаанд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Авлигын эсрэг нэгдье</li> <li>2. Үгүй гэж хэлээд өөрчилъе. Авлига, ашиг сонирхлын 12 зөрчлийг мэдээлэх утас #110</li> <li>3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авахад олон нийтэд тулгарч байсан хүнд суртлыг арилгажээ</li> <li>4. Албан тушаалтны ХОМ-тэй танилцах, мэдээлэл өгөх тухай</li> <li>5. Залуучуудаа авлигын эсрэг аянд нэгдэцгээе,</li> <li>6. ТОВШ аппликэйшнийг санал болгоё.</li> <li>7. Авлигын эсрэг хамтдаа</li> <li>8. 06 сарын 13-ны өдөр Үгүй гэж хэлээд өөрчилъе. Авлига ашиг сонирхлыг мэдээллэх тухай.</li> <li>9. 08 сарын 17-ны өдөр Иргэн танд төрийн үйлчилгээ авахад хүндрэлтэй байна уу</li> <li>10. 08 сарын 08-ны өдөр Авлигын эсрэг нэгдье. /Байгууллагын хуудсын ковер зураг 12 байршуулсан/</li> <li>11. 09 сарын 11-ны өдөр Тэгш эрхийхээ төлөө хамтдаа, авлигад идэгдэхгүйгээр өөрсдөө хичээл зүтгэлээрээ амжилтад хүрэхийг уриалж байна.</li> <li>12. 10 сарын 23, 31, 11 сарын 20, 22, 23, 27-ны өдрүүдэд авлигыг мэдээллэх тухай богино хэмжээний бичлэгүүдийг</li> <li>13. 12 сарын 06-ны өдөр үнэнч шударга</li> </ol>	
--	--	---	---	--

			байх тухай, зөвд зөв шударга зөв зэрэг нийт давхардсан тоогоор 20 шторк бичлэг, контентыг байгууллагын фэйсбүүк хуудсаар дамжуулан ажилтан албан хаагч, иргэн, олон нийтэд түгээн ажиллалаа. Баримтжуулсан үр дүнгээр шторк бичлэгийг давхардсан тоогоор 984 хүн үзэж, 32 шэйр хийж, 78 лайк авсан байна. “Авлигаас ангид төрийн үйлчилгээг хүргье” уриан дор байгууллагын 150 албан хаагч нэгдсэн. Мөн Авлигын эсрэг стикер наалтуудыг 12 хаалга, ариун цэврийн өрөөнд нааж урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлсэн.	
7	4.2.3.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.	Тайлант хугацаанд НЗДТГ-ын ХНХТөвөөс зохион байгуулсан нийт 5 сургалтад давхардсан тоогоор 352 ажилтан, албан хаагч сургалтад хамрагдсан. Мөн НЗДТГ-аас зохион байгуулсан “Алсын хараа-2050” сургалтад 6 албан хаагч амжилттай хамрагдаж сертификат гардан авсан.	Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2023 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 25 арга хэмжээ төлөвлөснөөс 22 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 1240 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 14 сургалтыг зохион байгуулсан бол 8 сургалтыг холбогдох дээд шатны байгууллагатай хамтран дотооддоо зохион байгуулан ажилласан. Үүнээс: харъяа хэлтсээс нийт 7 сургалтыг давхардсан тоогоор 172 ажилтан,	100%

			<p>албан хаагчийг хамруулсан байна.</p> <p>1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвөөс нийт 7 сургалтад давхардсан тоогоор 209 ажилтан, албан хаагчийг хамруулсан.</p> <p>2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 5,7-ны өдрүүдэд нийт 16 цагийн сургалтад 16 албан хаагч хамрагдсанаас 11 алба хаагч сертификат гардан авсан.</p>	
--	--	--	--	--

## 2. Дүн шинжилгээ

Арга хэмжээ тус бүрийн дүн шинжилгээ үнэлгээг харуулбал:

№	“Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний арга хэмжээ, Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан арга хэмжээ	Хариуцах хэлтэс, ажилтан	Дүн шинжилгээ	Үнэлгээ
1	2	3	4	5
1	3.1.4.5. “Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	Үнэлгээний хороо	Байгууллагын зоогийн газрын хүнсний бараа материалын 70 хувийг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс худалдан авч байна гэж тайлагнасан боловч цэвэрлэгээний бараа материал болон бусад худалдан авалтын талаар мэдээлэл байхгүй.	90%
2	4.1.1.2.“Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлнэ.	Мэдээлэл, холбоо, дохиоллын инженер Б.Бэлгүүтэй	Хурлын заал захиалгын системийг шинээр нэвтрүүлэн 2023 оны эхний хагас жилийн байдлаар 286 захиалгыг системээр дамжуулан авсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар НЗДТГ-ын 542 хурал, НИТХ-ын 18 хурал нийт 560 удаагийн хурлын танхимын захиалга хүлээн авч, давхардсан тоогоор 18600 хүнд цай кофе болон хурлын үйлчилгээг үзүүлсэн байна.	90%

3	4.1.1.3."Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулах.	Бичиг хэргийн эрхлэгч, шуурхай асуудал хариуцсан ажилтан Сувданчимэг	Байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, 2023 онд 326 албан бичгийг э-токен төхөөрөмж ашиглан тоон гарын үсгээр баталгаажуулан ажилласан.	90%
4	4.1.2.2."Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр үйлчлүүлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний стандарт бүхий хүртээмжтэй орчныг бүрдүүлнэ.	Ерөнхий инженер Б.Батсүрэн	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Ээлтэй орчин бүрдүүлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ширхэг тэргэнцрийг гардуулж өгсөн.	90%
5	4.1.4.1."Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	Захиргааны ахлах мэргэжилтэн Т.Азжаргал	Санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр тайлант хугацаанд нь гаргаж холбогдох газарт нь хүргүүлж ажиллалаа. Шилэн дансны веб хуудаст 23 төрлийн тайлан, мэдээг 105 удаа тухай бүр нь хугацааны хоцроолгүй, 8 мэдээллийг хугацаа хоцорч тайлагнасан байна. <i>/Нийт хэдэн төрлийн тайлан мэдээг давхардсан тоогоор хэдэн удаа нийтэд мэдээлэх үүрэгтэйг тодотгох, хугацаа хоцроож мэдээллэсэн тухай тайлбар байхгүй.</i>	90%
6	4.2.2.1."Төрийн албан хаагчдыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх авлига хээл хахууль авсан гэмт хэргийн гаралтын тоог бууруулах	Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Ю.Хүслэн	Арга хэмжээтэй холбоотой сургалтыг хангалттай зохион байгуулсан боловч нэгдсэн тоон мэдээлэл, үр дүнг тооцоогүй байна. Тус байгууллагад авлига хээл хахууль авсан гэмт хэрэгт холбогдсон албан хаагч байгаа эсэх мэдээлэл байхгүй.	90%
7	4.2.3.1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Сургалт, судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудад хамруулна.	Хүний нөөц, сургалт хариуцсан ажилтан А.Номинзул	-2023 оны сургалтын төвлөгөөний хэрэгжилт, хэрэгжилтийн хувийг тайлагнаагүй, 2023 онд зохион байгуулагдсан сургалтуудыг жагсаан бичсэн, -Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалт хамрагдсан байдлын	90%

		талаар мэдээлэлгүй.	
НИЙТ 7 АРГА ХЭМЖЭЭНИЙ ДУНДАЖ			90%

### 3.Дүгнэлт, зөвлөмж

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан нийт 202 арга хэмжээнээс Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар:

- Үндсэн хэрэгжүүлэх арга хэмжээ- Байхгүй,
- Хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ- 7 байна.

Байгууллагын хяналтад авсан нийт 7 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд, 7 арга хэмжээ-90 хувиар үнэлэгдсэн болно. **/Тодорхой үр дүнд хүрсэн**-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь/

Цаашид анхаарах зөвлөмж:

- Тайланд тавигдах стандарт, хэлбэрийн шаардлагыг хангуулах, Жишээ нь: 2023 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр тайлагнаж байгаа бол 2023 оны дөрөвдүгээр улирал гэж бичихгүй, албан хэрэг, бичиг хэргийн стандартын шаардлагыг хангах, үг үсэг, утга агуулга, хэл найруулгад анхаарах, биелэлтийг хэрэгжээд дууссан өнгөрсөн цаг дээр тайлагнах, арга хэмжээ тус бүрийн үр дүн, үр нөлөөг тооцдог байх,
- Тайланг газрын даргад танилцуулж, зөвшөөрсөн гарын үсэг авах, баталгаажуулах, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн албажуулах,
- Хөтөлбөрийн биелэлтийн дундаж хувийг гаргаж, үр дүн, үр нөлөөг тайлагнах,
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хангалттай мэдээллийг багтаасан байх,
- Хэрэгжилтийн тайланг хэлтэс, алба, албан хаагчаас хүлээж авч нэгтгэхдээ, он, сар, өдөр болон биелэлт гаргасан, хянасан албан хаагчийн гарын үсэг, тайлан мэдээг боловсруулсан байдал зэрэгт анхаарч, шаардлага хангаагүй, бүрдэл дутуу биелэлтийг хүлээн авахаас татгалзах, сайжруулалтад хугацаа заан буцааж байх гэсэн зөвлөмж өгч байна.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Б.УУГАНЦЭЦЭГ